



БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК

АУДИТОРЫН ТАЙЛАН

“УВС ХҮНС” ХК

2021 оны 12 дугаар сарын 31 нээр дуусвар болсон
санхүүгийн тайлан

**УЛААНБААТАР ХОТ
2022 ОН**



"БЭСТ ФОРТУНА АУДИТ" ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо

"Урбанек" ХХК-ийн байр 307 тоот

Утас: 324338, 98056465,

89116465, 98006465

И-мэйл: fortune2009audit@gmail.com

2022.03.25 № 64

танай _____-ны № _____-т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Бид "Увс хүнс" ХК-ийн 2021 оны 12 сарын 31-нээрх Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болсон Орлогын дэлгэрэнгүй, Өмчийн өөрчлөлт, Мөнгөн гүйлгээний тайлангууд болон эдгээр тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан Монгол улсын Сангийн сайдын тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой журам, зааврын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, бодитойгоор илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Аудитын явцад нягтлан бодох бүртгэлийн хувьд баримталсан зарчим, сонгож хэрэглэсэн арга, дотоод хяналтын системийг судлав. Санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэл бүхий нотолгоо олж авах зорилгоор аудитын түүврийн болон бусад арга горимуудыг гүйцэтгэсэн бөгөөд бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж итгэж байна.

Санхүүгийн тайлангийн талаар удирдлагын болон засаглал хариуцсан этгээдүүдийн хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг алдаа зөрчилгүй бэлтгэж, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож хэрэглэх, шударгаар толилуулахтай холбоотой, зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ. Засаглал хариуцсан этгээдүүд санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөн, санхүүгийн тайлангууд бүхэлдээ аливаа залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг хэмжээний буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах болон бидний дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан бэлтгэх юм. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч Аудитын олон улсын стандартын дагуу гүйцэтгэгдсэн аудитаар оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт мэдэгдэхүйц нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

ЗАХИРАЛ



Ж. ОЮУНЦЭЦЭГ

**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ
АУДИТЛАГДСАН ТАЙЛАН ТЭНЦЭЛ**

(мянган төгрөг)

Үзүүлэлтүүд	2021-12-31	
	Аудитлагдаагүй	Аудитлагдсан
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	660,001.2	660,001.2
Дансны авлага	79,068.0	79,068.0
Татвар, НДШ-ийн авлага	31,023.6	31,023.6
Бусад авлага	946,992.3	946,992.3
Бусад санхүүгийн хөрөнгө		-
Бараа материал	1,510,133.6	1,510,133.6
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	249,328.2	249,328.2
Бусад эргэлтийн хөрөнгө		-
Эргэлтийн хөрөнгийн дүн	3,476,546.9	3,476,546.9
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	1,573,540.4	1,573,540.4
Биет бус хөрөнгө		-
Урт хугацаат хөрөнгө оруулалт		-
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		-
Биологийн хөрөнгө		-
Бусад эргэлтийн бус хөрөнгө		-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,573,540.4	1,573,540.4
Нийт хөрөнгийн дүн	5,050,087.3	5,050,087.3
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	886,708.3	886,708.3
Цалингийн өглөг	22,177.0	22,177.0
Татварын өр	115,832.8	115,832.8
НДШ-ийн өглөг	1,936.1	1,936.1
Богино хугацаат зээл	650,000.0	650,000.0
Хүүгийн өглөг	7,296.6	7,296.6
Ногдол ашгийн өглөг		-
Урьдчилж орсон орлого	29.9	29.9
Бусад богино хугацаат өр төлбөр	48,927.6	48,927.6
Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,732,908.3	1,732,908.3
Урт хугацаат зээл	950,000.0	950,000.0
Хойшлогдсон татварын өр		-
Бусад урт хугацаат өр төлбөр		-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	950,000.0	950,000.0
Өр төлбөрийн нийт дүн	2,682,908.3	2,682,908.3
Эзэмшигчийн өмч		
Өмч: а) Төрийн		-
б) Хувийн		-
в) Хувьцаат	14,736.7	14,736.7
Нэмж төлөгдсөн капитал		-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	847,420.5	847,420.5
Эздийн өмчийн бусад хэсэг		-
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	1,505,021.8	1,505,021.8
Эзэмшигчийн өмчийн дүн	2,367,179.0	2,367,179.0
Өр төлбөр ба эзэмшигчийн өмчийн дүн	5,050,087.3	5,050,087.3

"УВС ХҮНС" ХК

2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН АУДИТЛАГДСАН
ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

(мянган төгрөг)

Үзүүлэлтүүд	2021-12-31	
	Аудитлагдаагүй	Аудитлагдсан
Борлуулалтын орлого	4,179,403.6	4,179,403.6
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	3,011,256.0	3,011,256.0
Нийт ашиг (алдагдал)	1,168,147.6	1,168,147.6
Үйл ажиллагааны зардал		
Түрээсийн орлого		-
Хүүгийн орлого	179.1	179.1
Ноогдол ашгийн орлого	-	-
Эрхийн шимтгэлийн орлого	-	-
Бусад орлого		-
Борлуулалт маркетингийн зардал		-
Ерөнхий ба удирдлагын зардал	936,460.2	936,460.2
Санхүүгийн зардал		-
Бусад зардал	6,562.6	6,562.6
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(0.9)	(0.9)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	491.7	491.7
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		-
Бусад ашиг (алдагдал)		-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	225,794.7	225,794.7
Орлогын татварын зардал	23,217.8	23,217.8
Татварын дараах ашиг (алдагдал)	202,576.9	202,576.9
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	202,576.9	202,576.9
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
Бусад олз (гарз)	-	-
Орлогын нийт дүн	202,576.9	202,576.9
Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	-	-

03
25

**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН
АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

(мянган төгрөг)

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	14,736.7	847,420.5		1,121,329.1	1,983,486.3
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
Залруулсан үлдэгдэл	14,736.7	847,420.5	-	1,121,329.1	1,983,486.3
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				181,115.8	181,115.8
Бусад дэлгэрэнгүй орлого	-		-		-
Өмчид гарсан өөрчлөлт					
Зарласан ногдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-				-
2020 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	14,736.7	847,420.5	-	1,302,444.9	2,164,602.1
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
Залруулсан үлдэгдэл	14,736.7	847,420.5	-	1,302,444.9	2,164,602.1
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				202,576.9	202,576.9
Бусад дэлгэрэнгүй орлого	-				-
Өмчид гарсан өөрчлөлт					
Зарласан ногдол ашиг	-				-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-				-
2021 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	14,736.7	847,420.5	-	1,505,021.8	2,367,179.0

03
25

"УВС ХҮНС" ХК

2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН
ГҮЙЛГЭЭНИЙ АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

(мянган төгрөг)

Үзүүлэлтүүд	2021-12-31	
	Аудитлагдаагүй	Аудитлагдсан
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	4,856,558.6	4,856,558.6
Борлуулалтын болон худалдан авагчдаас орсон мөнгө	4,856,558.6	4,856,558.6
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Буцаан авсан албан татвар	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
Бусад мөнгөн орлого	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	4,986,148.4	4,986,148.4
Ажиллагсад олгосон мөнгө	453,458.4	453,458.4
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	95,000.0	95,000.0
Бараа, материал худалдан авахад төлсөн	3,941,769.3	3,941,769.3
Ашиглалтын зардалд төлсөн	11,491.1	11,491.1
Түлш, шатахуун, тээврийн хөлс сэлбэг хэрэгсэлд төлсөн	56,712.9	56,712.9
Хүүний төлбөрт төлсөн	78,861.9	78,861.9
Татварын байгууллагад төлсөн	348,854.8	348,854.8
Даатгалын байгууллагад төлсөн	-	-
Бусад мөнгөн зарлага	-	-
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(129,589.8)	(129,589.8)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	1,679.10	1,679.1
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	1,500.0	1,500.0
Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	-	-
Хүлээн авсан хүүний орлого	179.1	179.1
Бусад мөнгөн орлого	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	16,600.0	16,600.0
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	16,600.0	16,600.0
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(14,920.9)	(14,920.9)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	1,100,000.0	1,100,000.0
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,100,000.0	1,100,000.0
Хувьцаа болон өмчийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	414,473.6	414,473.6
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	414,473.6	414,473.6
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн мөнгө	-	-
Хувьцаа буцааж худалдан авахад төлсөн	-	-
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	685,526.4	685,526.4
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	541,015.7	541,015.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	118,985.5	118,985.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	660,001.2	660,001.2

ТАЙЛАГНАГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД:	“УВС ХҮНС” ХК
ХАЯГ:	Увс аймаг, Улаангом сум, 5-р баг
ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН ОГНОО:	1942 оны 02 дугаар сарын 18 1992 - ТӨХорооны шийдвэрээр төрийн өмч давамгайлсан “Чиндмэн” ХК, 1999- Бүтэц зохион байгуулалтаа өөрчлөн “Увс хүнс” ХК болсон.
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ДУГААР:	1510001008
РЕГИСТРИЙН ДУГААР:	2001969
ӨМЧИЙН ХЭЛБЭР:	Хувьцаат компани
ҮЙЛ АЖИЛЛААГААНЫ ЧИГЛЭЛ:	<ul style="list-style-type: none"> ○ 1101 Спирт, архи зэрэг согтууруулах ундаа үйлдвэрлэл ○ 1074 Гоймон, пүнтүүз болон энэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл ○ 0125 Жимс, жимсгэнэ тариалалт ○ 4630 Ундаа, цэвэр усны үйлдвэрлэл ○ 1071 Талх, талхан бүтээгдэхүүн үйлдвэрлэл ○ 1080 Жимс, ногоо боловсруулах, хадгалах
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ:	14,736,726.00 төгрөг
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ	ХХААХҮ-ийн сайдын 2010 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/152 дугаар тушаалыг үндэслэн “Архины үйлдвэрлэл”-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан.
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:	Л.Мөнхнаранг 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдрөөс гүйцэтгэх захирлаар томилсон.
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ:	Б.Дэлгэрмааг 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 20/50 дугаар тушаалаар нягтлан бодогчоор томилсон.

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2020.12.31	2021.12.31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө	2,492,383.1	3,476,547.0
Мөнгө ба түүнтэй адилтгах өрөнгө	118,985.5	660,001.3
Дансны авлага	338,282.5	79,068.0
Татвар, НДШ-ийн авлага	22,532.9	31,023.6
Бусад авлага	842,139.6	946,992.3
Бараа материал	1,032,743.0	1,510,133.6
Урьдчилж төлсөн зардал	137,699.6	249,328.2
Эргэлтийн бус хөрөнгө	2,439,311.2	2,169,745.5
Үндсэн хөрөнгө	1,650,970.9	1,573,540.4
Биет бус хөрөнгө	-	-
НИЙТ ХӨРӨНГӨ	4,143,354.1	5,050,087.4
Богино хугацаат өр төлбөр	1,978,752.0	1,732,908.4
Дансны өглөг	850,598.2	886,708.3
Цалингийн өглөг	15,524.8	22,177.1
Татварын өглөг	127,106.8	115,832.8
НДШ-ийн өглөг	586.8	1,936.1
Богино хугацаат зээл	814,473.6	650,000.0
Хүүний өглөг	2,942.5	7,296.6
Урьдчилж орсон орлого	5.0	29.9
Бусад өглөг	167,514.3	48,927.6
Урт хугацаат өр төлбөр	-	950,000.0
Урт хугацаат зээл	-	950,000.0
Өр төлбөрийн нийт дүн	1,978,752.0	2,682,908.4
ЭЗДИЙН ӨМЧ		
Хувьцаат капитал	14,736.7	14,736.7
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	847,420.5	847,420.5
Хуримтлагдсан ашиг	1,302,444.9	1,505,021.8
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,164,602.1	2,367,179.0
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,143,354.1	5,050,087.4

Холбогдох нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

(мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2020.12.31	2021.12.31
Борлуулалтын орлого	2,776,294.4	4,179,403.6
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	3,524,582.6	3,011,256.0
Нийт ашиг	1,106,098.2	1,168,147.6
Хүүний орлого	1,790.7	179.1
Бусад орлого	520.1	
ЕРӨНХИЙ БА УДИРДЛАГЫН ЗАРДАЛ	903,862.7	936,460.2
Бусад зардал	8,000.0	6,562.6
Гадаад валютын ханшийн зөрүүний олз, (гарз)	5,343.4	(0.9)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз, (гарз)	40.0	491.7
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	201,929.7	225,794.7
Орлогын татварын зардал	20,813.9	23,217.8
ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР ҮР ДҮН	181,115.8	202,576.9

Холбогдох нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	14,736.7	847,420.5	1,121,329.1	1,983,486.3
Бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
Залруулсан үлдэгдэл				
Тайлант үеийн цэвэр үр дүн			181,115.8	181,115.8
Бусад дэлгэрэнгүй орлого				
Өмчид гарсан өөрчлөлт				
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэргэжсэн дүн				
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	14,736.7	847,420.5	1,302,444.9	2,164,602.1
Бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
Залруулсан үлдэгдэл				
Бусад дэлгэрэнгүй орлого				
Өмчид гарсан өөрчлөлт				
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
Тайлант үеийн цэвэр үр дүн			202,576.9	202,576.9
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	14,736.7	847,420.5	1,505,021.8	2,367,179.0

Холбогдох нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	(мянган төгрөгөөр)	
ҮЗҮҮЛЭЛТ	2020.12.31- ний үлдэгдэл	2021.12.31-ний үлдэгдэл
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(276,869.6)	(129,589.8)
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	2,836,119.1	4,856,558.6
Борлуулалтын орлого	2,836,119.1	4,856,558.6
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	3,112,988.7	4,986,148.4
Ажиллагсдад олгосон	437,390.7	453,458.5
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	41,900.0	95,000.0
Бараа материал худалдан авахад төлсөн	1,976,540.5	3,941,769.3
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	99,638.9	11,491.1
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	71,501.7	56,712.9
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн	451,004.1	221,219.5
Хүүний төлбөрт төлсөн	51,983.4	78,861.9
Татварын байгууллагад төлсөн	434,033.5	348,854.8
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(24,002.3)	(14,920.9)
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	11,200.0	1,500.0
Хүлээн авсан хүүний орлого	1,790.7	179.1
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	36,993.0	16,600.0
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага	-	-
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	399,473.6	685,526.4
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	500,000.0	1,100,000.0
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	100,526.4	414,473.6
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	98,601.7)	541,015.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,383.9	118,985.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	118,985.5	660,001.2

Холбогдох нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

АУДИТЫН ДҮГНЭЛТИЙН ТОДРУУЛГА

2021.12.31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлангийн тухай)

"Увс хүнс" ХК-нь анх 1942 оны 02 дугаар сарын 18-ны өдөр "Идэш тэжээлийн комбинат" нэртэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд 1973 оноос Хүнсний комбинат болон өргөжиж, 1992 онд Төрийн өмчийн хорооны шийдвэрээр төрийн өмч давамгайлсан "Чиндмэн" хувьцаат компани болон зохион байгуулагдсан байна. Улмаар 1999 онд бүтэц зохион байгуулалтаа өөрчлөн "Увс хүнс" хувьцаат компани болон өнөөг хүртэл үйл ажиллагаагаа явуулж байна. "Увс хүнс" хувьцаат компани нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 112 716 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх дүрмийн сантай, 1 үүсгэн байгуулагчтай ажиллаж байна.

"Увс хүнс" ХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангуудыг Монгол Улсын Аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын Олон Улсын стандарт /АОУС/, Сангийн Яам, Санхүүгийн Зохицуулах хорооны холбогдох журам, шийдвэрүүдийн хүрээнд шалгаж танилцлаа.

Аудитлагдсан санхүүгийн тайлан нь зөвхөн 2021 оны жилийн эцсийн хөрөнгө, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг тусган үзүүлж байгаа болно.

Байгууллагын удирдлагаас санхүүгийн тайланг тасралтгүй байх зарчимд үндэслэн бэлтгэж, орлого ба зардлыг аккрузель суурьт зарчмаар хүлээн зөвшөөрсөн.

"Увс хүнс" ХК-ийн тайлант оны орлого, зарлагын төсөв, үйл ажиллагааны төлөвлөгөөг 2021 оны 04 дүгээр сарын хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор баталж, гүйцэтгэлийг тайлагнан ажилласан байна.

"Увс хүнс" ХК нь нягтлан бодох бүртгэл хөтөлж санхүүгийн тайлан гаргахдаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Сангийн яамнаас гаргасан заавар, журмуудыг баримталж байна.

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлого 4,179,403.6 мянга, хүүний орлого 179.1 мянга, нийт 4,179,582.7 мянган төгрөгийн орлогыг хүлээн зөвшөөрч нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.

1. Мөнгөн хөрөнгө

Байгууллагын мөнгөн хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө, харилцах данснаас бүрдсэн ба мөнгөн хөрөнгүүдийг валютын төрөл, зориулалт, байршлаар ангилан, нэрлэсэн үнээр үнэлж тэнцэлд тусгасан байна. Бид мөнгөн хөрөнгийн дансуудын тайлант оны гүйлгээ ба үлдэгдлийг аудитын түүврийн ба тулган баталгаажуулалтын аргаар тестлэн шалгаж дараах мэдээллийг олж тогтоов. Үүнд:

Касс дахь бэлэн мөнгө

/мянган төгрөгөөр/

Төрөл	2020.12.31	2021.12.31	Өөрчлөлт
Бэлэн мөнгө ₮	410.3	1,075.4	665.1

Банкин дахь харилцах данс

(мянган төгрөгөөр)

Д/д	Харилцагч банк	Дансны дугаар	2020.12.31	2021.12.31	Өөрчлөлт
1	Төрийн банк ₮	162000888885	876.0	650,139.5	649,263.5
2	ХААН банк ₮	5822193252	26,009.2	618.9	(25,390.3)
3	ХААН банк ₮	5822414547	-	4.0	4.0
3	Худалдаа хөгжлийн банк ₮	499104921	125.9	125.9	-
4	Голомт банк ₮	6200000529	8,437.5	2,788.8	(5,648.7)
5	Хас банк ₮	5000499620	77,864.5	88.1	(83,601.3)
6	Хас банк ₮	5004497454		9.0	9.0
7	Төрийн банк \$	240305830309	2309.3	69.6	(2,239.7)
8	Төрийн банк руб	240309932703	431.8	402.0	(29.8)
9	Худалдаа хөгжлийн банк \$	499130735	2,260.9	2,260.5	-
10	Хас банк CNY	5002910050	236.7	132.1	(104.6)
11	ХААН банк руб	5822353401	23.5	2,287.4	2,263.9
Харилцахын дүн			118,575.3	658,925.8	540,350.5

Тайлант оны эцэст Төрийн банкнаас богино хугацаатай зээл авсанаас мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 540,350.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

2. Авлага

Авлагыг ажилчдаас авах авлага, татварын авлага, холбоотой талаас авах авлага гэж ангилан, нэрлэсэн үнээр бүртгэлд тусгасан ба авлагуудын тооцоолол, хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, стандарт, заавар аргачлалын зарчимд нийцэж байна. Мэдээллийг ашиглан дараах мэдээллийг бэлтгэв.

(мянган төгрөгөөр)

Д/д	Авлагын ангилал	2020.12.31	2021.12.31	Өөрчлөлт
1	Борлуулалтын авлага	59,855.9	79,067.9	19,212.0
2	Ажилчдаас авах авлага	45,132.9	53,510.6	8,377.7
3	Холбоотой талаас авах авлага	797,006.7	893,481.7	96,475.0
4	НӨАТ-ын авлага	1,590.8	8,386.3	6,795.5
5	Онцгой албан татварын авлага	20,942.1	22,637.3	1,695.2
Авлагын дүн		924,528.4	1,057,083.8	132,555.4

Тайлант оны эцэст авлага өмнөх оноос 132,555.4 мянган төгрөгөөр нэмэгдсэний дотор холбоотой талаас авах авлага 96,475.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Оны эцэст авлагын дансанд 971.1 мянган төгрөгийн авлагыг хасах утгатайгаар бүртгэсэн нь авлага, өглөгийн дансны бодит үлдэгдлийг бууруулсан байна.

Борлуулалтын болон ажилчдаас авах авлагын дансанд 1-ээс дээш жил болсон 10 хүнтэй холбогдох 50,900.7 мянган төгрөгийн авлага найдваргүй болох эрсдэл үүсэж болзошгүй байна.

3. Урьдчилж төлсөн зардал, тооцоо

(мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2020.12.31	2021.12.31
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	137,699.5	249,328.2
Урьдчилж төлсөн тооцооны дүн	137,699.5	249,328.2

4. Бараа материал

Д/д	Бараа материалын төрөл	(мянган төгрөгөөр)		
		2020.12.31	2021.12.31	Өөрчлөлт
1	Түүхий эд материал	459,571.9	939,597.1	480,025.2
2	Бэлэн бүтээгдэхүүн	345,943.1	321,533.4	(24,409.7)
3	Хангамжийн материал	89,044.7	249,003.1	159,958.4
	Дүн	894,559.7	1,510,133.6	615,573.9

Тайлант онд түүхий эд материал, хангамжийн материалын үлдэгдэл өмнөх оноос 639,983.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь Ковид-19 цар тахал, хөл хориотой холбоотойгоор хомсдол үүсэхээс сэргийлэн тодорхой хэмжээний нөөц үүсгэсэнтэй холбоотой байна.

5. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгүүдийг түүхэн өртгөөр үнэлж, төрөл ба зориулалтаар нь ангилан нэрийн дансанд бүртгэж ашиглах хугацаанд шулуун шугамын аргаар элэгдүүлэн, дэлгэрэнгүй бүртгэлүүд ба тэнцэлд хөрөнгийн анхны өртөг ба хуримтлагдсан элэгдлийг зэрэгцүүлэн үзүүлсэн байна.

Тайлант онд 141,488.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, компьютер техник хэрэгсэл худалдан авч, 16,600.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл акталж, худалдан, данснаас хассан байна. Тайлангийн жилд нийт 217,910.8 мянган төгрөгийн элэгдэл байгуулж, удирдлагын зардлаар бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгийн анхны өртөгийн бүртгэлд материаллаг алдаа илрээгүй бөгөөд харин тооцоолсон нийт элэгдлийг удирдлагын зардалд бүртгэсэн алдаа илэрлээ. Тайлангийн эхний ба эцсийн үлдэгдлүүдийг дор үзүүлэв.

Хөрөнгө	(мянган төгрөгөөр)					
	Анхны өртөг		Хуримтлагдсан элэгдэл		Үлдэгдэл өртөг	
	2020.12.31	2021.12.31	2020.12.31	2021.12.31	2020.12.31	2021.12.31
Үндсэн хөрөнгө	3,285,386.6	3,410,275.2	1,634,415.7	1,836,734.8	1,650,970.9	1,573,540.4
Биет бус хөрөнгө	1,036.8	1,036.8	1,036.8	1,036.8	-	-
ДҮН	3,286,423.4	3,411,312.0	1,340,860.2	1,655,819.2	1,650,970.9	1,573,540.4

5. Өр төлбөр

Богино хугацаат өр төлбөрийг нэрлэсэн үнэ цэнээр үнэлж, харилцагч байгууллага хуулийн этгээд бүрээр данс нээж хөтлөн тайлангийн эхний ба эцсийн өдрөөрх богино хугацаатай өглөгүүдийг дараах дүнгээр илэрхийлж анхан шатны болон хураангуй бүртгэлүүдэд тусгасан байна. Үүнд:

Төрлүүд	(мянган төгрөгөөр)		
	2020.12.31	2021.12.31	Өөрчлөлт
Дансны өглөг	850,598.2	886,708.3	36,110.1
Цалингийн өглөг	15,524.7	22,177.0	6,652.3
Татварын өглөг	127,106.8	115,832.8	(11,274.0)
НДШ-ийн өглөг	586.8	1,936.1	1,349.3
Богино хугацаат зээл	814,473.6	650,000.0	(164,473.6)

Хүүний өглөг	2,942.5	7,296.6	4,354.1
Урьдчилж орсон орлого	5.1	29.9	24.8
Бусад богино хугацаат өглөг	167,514.4	48,927.6	(118,586.8)
Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,978,752.1	1,732,908.3	(245,843.8)

Өр төлбөрийн бүртгэл, үлдэгдлийн тооцоолол материаллаг алдаагүй гэж үзэж байна. Өглөгийн үлдэгдэл нийт дүнгээрээ 245,843.6 мянган төгрөгөөр буурсан боловч холбоотой талд өгөх өглөг 36,110.1 мянган төгрөгөөр өссөн байна.

6. Эзэмшигчийн өмч

(мянган төгрөгөөр)

Д/д	Өмчийн төрөл	2020.12.31	2021.12.31	Өөрчлөлт
1	Хувьцаат капитал	14,736.7	14,736.7	-
2	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	847,420.5	847,420.5	-
3	Хуримтлагдсан ашиг	1,302,444.9	1,505,021.8	202,576.9
	Дүн	2,164,602.1	2,367,179.0	202,576.9

Тайланд онд өмчид өөрчлөлт ороогүй бөгөөд санхүүгийн үр дүнгээр хуримтлагдсан ашиг 202,576.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Компанийн дүрэм болон Монголын хөрөнгийн биржийн бүртгэлээр нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 112,716 ширхэг хувьцаатай бөгөөд хувьцаат капиталын дүн 3,465.1 мянган төгрөгийн зөрүүтэй байна.

Компанийн энгийн хувьцааны 99.84 хувь буюу 112,532 ширхэг хувьцааг 1 хүн эзэмшиж байна.

7. Орлого

(мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2020.12.31	2021.12.31
Үйл ажиллагааны орлогын дүн	2,778,605.2	4,179,582.7
Борлуулалтын орлого	2,776,294.4	4,179,403.6
Хүүний орлого	1,790.7	179.1
Бусад орлого	520.1	-
Үйл ажиллагааны зардлын дүн	2,574,058.9	3,947,716.2
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,670,196.2	3,011,256.0
Ерөнхий ба удирдлагын зардал	903,862.7	936,460.2
Тайлант үеийн цэвэр үр дүн	181,115.8	202,576.9

Өмнөх оноос орлого 1,400,977.5 мянган төгрөгөөр буюу 50.4 хувиар, үйл ажиллагааны зардал 1,373,657.3 мянган төгрөгөөр буюу 53.4 хувиар тус тус өссөн ба 202,576.9 мянган төгрөгийн ашигтай гарсныг санхүүгийн тайланд тусгасан байна. Аудитын сонголтот түүвэр ба бусад аргаар гүйцэтгэсэн сорилын үр дүнг үндэслэн байгууллагын үр дүнгийн тайлангаар тодорхойлогдсон орлого, зарлага, үр дүн нь материаллаг алдаа агуулаагүй гэж үзэж байна.

8. Ерөнхий ба удирдлагын зардал

ҮЗҮҮЛЭЛТ	(мянган төгрөгөөр)	
	2020.12.31 (мян.төг)	2021.12.31 (мян.төг)
Үндсэн ба нэмэгдэл цалин	345,591.4	390,104.4
Нийгмийн даатгалын шимтгэл	16,806.6	38,961.9
Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	34,705.4	29,627.3
Албан томилолтын зардал	4,976.3	370.0
Мэргэжлийн үйлчилгээний зардал	2,262.5	6,177.2
Сургалтын зардал	3,740.0	2,380.4
Элэгдлийн зардал	225,710.8	217,910.8
Түрээсийн зардал	8,296.4	8,168.6
Ашиглалтын зардал	30,490.7	18,544.8
Цэвэрлэгээ, үйлчилгээний зардал	13,887.1	15,533.4
Засвар үйлчилгээний зардал	51,354.7	59,663.2
Бичиг хэргийн зардал	16,357.1	8,569.9
Шуудан холбооны зардал	7,335.8	6,463.0
Шатахууны зардал	29,512.8	22,138.9
Зээлийн хүүгийн зардал	51,983.4	78,861.9
Зар сурталчилгааны зардал	18,374.1	-
Тээврийн зардал	957.7	870.4
Бусад зардал	41,519.9	32,114.0
Үйл ажиллагааны зардлын дүн	903,862.7	936,460.3

Ерөнхий ба удирдлагын зардал өмнөх оноос 32,597.6 мянган төгрөгөөр нэмэгдсэний дотор Ковид-19 цар тахалтай холбоотойгоор Засгийн газраас авч хэрэгжүүлсэн хөнгөлөлт, чөлөөлөлтийн хугацаа дууссантай холбоотойгоор НДШ-ийн зардал өмнөх оноос 22,155.3 мянган төгрөгөөр өссөн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

АУДИТОРЫН ЗӨВЛӨМЖ

2022 оны 03 дугаар сарын 25

Улаанбаатар хот

"Увс хүнс" ХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудит хийж энэхүү товч санал зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Мөнгөн хөрөнгө

Аудиторын ажиглалт:

а) "Хархираан хөгжил" ХХК-ийн өмнөөс холбогдох зардлуудыг тухай бүр төлж бүртгэлийн ажиллагааг хүндрүүлсэн байна.

б) Мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын баримтуудад гарын үсгийн бүрдэл дутуу, анхан шатны баримтын иж бүрдэл хангалтгүй;

Аудиторын зөвлөмж:

а) Харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хоорондын төлбөр тооцоо, бараа бүтээгдэхүүн худалдан авах журмыг тодорхой болгон мөрдөж ажиллах;

б) Анхан шатны баримтын бүрдүүлэлтийг сайжруулж ажиллах;

2. Авлага

Аудиторын ажиглалт:

а) Олон жил болсон, найдваргүй болох эрсдэлтэй, хаяг, байршил тодорхойгүй авлага байна. Холбоотой талын авлага, өглөгийн тооцоо ихэнх хувийг эзэлж байгаа.

б) Жилийн эцсийн үлдэгдлээрх хасах утгатай авлага нь санхүүгийн тайланд авлага, өглөгийн дансны үлдэгдлийг бууруулж, үлдэгдэл алдаатай тайлагнагдсан байна

Аудиторын зөвлөмж:

а) Найдваргүй авлагын нөөц байгуулах замаар эрсдэлээс сэргийлэх,

б) Хасах утгатай авлагын үлдэгдлийг өглөгийн, өглөгийг авлагын данс руу шилжүүлэн тайлагнаж байх

с) Холбоотой талын авлага, өглөгийн тооцоог хэлэлцэн шийдвэрлэх

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

Аудиторын ажиглалт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байгууллагын хэрэгцээ, шаардлага хангаагүй

Аудиторын зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2."Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасныг хэрэгжүүлж мэргэжлийн байгууллагатай хамтран Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг сайжруулж боловсруулан, баталж мөрдөх

4. Хөрөнгийн бүртгэл

Аудиторын ажиглалт:

Байгууллагын эзэмшлийн 9006 м2 газар эзэмших эрхийг санхүүгийн тайланд тусгаагүй.

Аудиторын зөвлөмж:

Газар эзэмших эрхийг төлсөн татварын дүнгээр үнэлж биет бус хөрөнгөнд бүртгэх

5. Зардлын бүртгэл

Аудиторын ажиглалт:

а) Дуусаагүй үйлдвэрлэлийн зардал, борлуулсан бүтээгдэхүүний өртөгт хамаарах үйлдвэр, цехийн барилга, тоног төхөөрөмж бусад үндсэн хөрөнгийн элэгдэл, ашиглалт, цэвэрлэгээ үйлчилгээ, засварын зардлуудыг удирдлагын зардалд бүртгэсэн.

б) Зээлийн хүүгийн зардлыг удирдлагын зардалд бүртгэсэн

Аудиторын зөвлөмж:

а) Дуусаагүй үйлдвэрлэлийн зардлыг шууд хөдөлмөрийн, шууд материалын, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал гэж санхүүгийн программд ангилан бүртгэх, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлыг цалин, НДШ, материалаас бусад үйлдвэрлэлийн зардлуудыг (урсгал засвар, элэгдэл, цэвэрлэгээ үйлчилгээ, ус, дулаан, цахилгаан, үйлдвэрийн ажилчдын хоол, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл, шатахуун, харуул хамгаалалт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, бусад зардал) зүйл ангиар ангилж бүртгэж байх

б) Зээлийн хүүгийн зардлыг Орлогын дэлгэрэнгүй тайланд санхүүгийн зардлаар тайлагнаж байх

6. Өмч, хувьцаа

Аудиторын ажиглалт:

а) Компанийн тухай хуулийн 83.3."Хувь хүн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж байгаа тохиолдолд уг этгээд компанийн гүйцэтгэх захирал байна", 83.4."Компанийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч этгээд нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байж болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга байхыг хориглоно", компанийн дүрмийн 28-д "ТУЗ-ийн дарга нь компанийн гүйцэтгэх захирал байж болохгүй" гэсэн заалтууд хэрэгжээгүй байна.

б) Компанийн энгийн хувьцааны 99.84 хувийг 1 хүн эзэмшсэнээр хувьцааны арилжаа идэвхгүй болж Монголын хөрөнгийн биржээс тогтоосон "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 23.11 дэх заалтыг хангахгүй байгаагаас 2021 оны 11 дүгээр сарын 15-нд анхааруулга ирүүлсэн байна.

с) 2017 оны 05 сарын 23-ны өдөр Улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрийн хөрөнгийн хэмжээг хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 847,420.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж бүртгүүлсэн.

Аудиторын зөвлөмж:

- а) Компанийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах,
- б) Компанийн засаглалыг сайжруулах, хувьцааны арилжааг идэвхжүүлэх тодорхой ажил зохион байгуулах,
- в) Санхүүгийн тайлан, Компанийн дүрэм, Монголын хөрөнгийн биржийн бүртгэлээрх өмчийн 3,465.1 мянган төгрөгийн зөрүү, Улсын бүртгэлийн гэрчилгээнд хийлгэсэн өөрийн хөрөнгийн өөрчлөлтийг шийдвэрлэх.

7. Санхүүгийн баримт

Аудиторын зөвлөмж:

- а) Банкин дахь харилцах дансны хуулгыг хэвлэн санхүүгийн баримтанд үдэж байх
- б) Баримтыг архивын дүрмийн дагуу үдэж хадгалах

ЗӨВЛӨМЖ ӨГСӨН:

"БЭСТ ФОРТУНА АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

АХЛАХ АУДИТОР



Ж.ОЮУНЦЭЦЭГ

Б.НАРАНГЭРЭЛ